



ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ
ДАРГА Д.БАТБАЯР ТАНАА

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, П.Гэндэнгийн гудамж,
5 дугаар баг, Арвайхээр сум, Өвөрхангай аймаг, 62173,
Утас/Факс: (976) 7032 3253,

Цахим шуудан: uvurkhangai@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2024.02.14 № 132
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Хужирт сумын Төрийн сангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Хужирт сумын Төрийн сангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Сумын ЗДТГ нь Засаг даргын нөөц хөрөнгийн зардлаас эрх бүхий дээд байгууллагаас тус суманд албан томилолтоор ажилласан албан хаагчдын хоол, байрны үнийг төлсөн, Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас сургуулийн эко булан тохижуулахад 5,000.0 мянган төгрөг, хогийн цэг дарах, янзлах зардалд 43,500.0 мянган төгрөг, нийт 48,500.0 мянган төгрөгийг хууль тогтоомжийн дагуу зарцуулаагүй, Нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлаас нийт ажилтнуудад 2,560.0 мянган төгрөгийн бэлэг олгосон, Бараа үйлчилгээний бусад зардлаас 200.0 мянган төгрөгийг "Сэмжид Хужирт" рашаан сувиллын ойн арга хэмжээнд дэмжлэг олгосон байна.

ИТХ нь мэргэжилтэнд бичиг хэргийн ажлыг хавсран гүйцэтгүүлж 2,039.4 мянган төгрөгийн нэмэгдэл цалин илүү олгосон, Бараа үйлчилгээний бусад зардлаас 8,069.7 мянган төгрөгийг зориулалт бус зарцуулсан.

ГХУСАХ-ний зардлаас 1,100.0 мянган төгрөгийг чиг үүргийн дагуу зарцуулаагүй.

Хоршоо хөгжүүлэх сангийн зээлдэгчдийн хувийн хэрэг, анхан шатны баримт хангалтгүй бүрдүүлсэн, төслийн хэрэгжилтийн явц, үр дүнгийн талаарх бусад мэдээллийн баримт материалыг бүрдүүлээгүй, хяналтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Эдгээр зөрчлүүд нь бидний тооцсон материаллаг байдлын түвшнээс давсан ба Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4.1-д "төсвийн үр ашигтай, хэмнэлтэй байхаар төлөвлөж, зарцуулах, УСНББОУС-12,17 дугаар стандартыг хангаагүй ба санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх, үнэн зөв байдал, эрх ба үүрэг зэрэг батламж мэдэгдлүүдтэй нийцэхгүй байна.

015030666

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд тус сумын нэгтгэсэн тайланд 2,797.3 сая төгрөгийн орлогыг бүртгэжээ. Үүний 726.7 сая төгрөг нь санхүүгийн дэмжлэг, 324.7 сая төгрөг нь ОНХС-аас, 150.5 сая төгрөг нь нэмэлт санхүүжилтээр, 296.6 сая төгрөг нь СХСан, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос, 1,298.8 сая төгрөг нь татварын болон татварын бус орлогоос тус тус бүрджээ.

Аудитын гол асуудал

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлуудыг үздэг. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

Сумын нэгтгэсэн санхүүгийн тайланд ЗДТГ, ИТХ, Хужирт-Эрдэс баялаг ОНӨААТҮГ, СХСан, ОНХСан, ЭХСан, ОНӨОрлогын санхүүгийн тайлан, боловсрол эрүүл мэнд, соёлын байгууллагуудын тогтмол зардал нэгтгэгдсэн.

Бусад асуудлын хэсэг

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР  БАТЖАРГАЛ

